



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2019.02.15 № 03/531

танай _____-ны № _____-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Тус яамнаас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт: 21 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

08 00558

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

-Барилга, хот байгуулалтын яам

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Д.Монголжингоо, холбогдох утас: 99186120

-2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

№	ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА ХЭСЭГ	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5.	Хэрэгжих нийт хугацаа	6 жил
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 4. худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 5. шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p>Зорилт 6. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;</p> <p>Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p>

		<p>Зорилт 8. иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 9. улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;</p> <p>Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 11. авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.</p>	
7.	Зардал	Төсөв	24,962.4
Үүнд:		Төсөв	Гүйцэтгэл
1-р үе шат		14,308.9	499.0
2-р үе шат		10,653.5	-
Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг			
8.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Гүйцэтгэлийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ бүрээр, хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хамт зохих талбарт бичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:	<p>4.1.1.1.Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яамны цахим хуудсанд /mcud.gov.mn/ мэдээ, мэдээлэл, булан зэрэг аль ч хэлбэрээр Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох боломжтой төдийгүй тус цахим хуудсанд “ИЛ ТОД БАЙДАЛ” цэсэнд хүний нөөцийн ил тод байдал булан ажилладаг бөгөөд тус буланд дээрх мэдээллийг оруулан ажиллаж байна. • Мөн яамны эрх бүхий албан тушаалтнаас холбогдох журмын дагуу ХАСУМ-тай холбоотой мэдээллийг авч хянан албан бичгийн хамт АТГ-т хянуулахаар хүрүүлж ажилласан. Тайлант хугацаанд 27 хүний ХАСУМ-ийг хүлээн авч хянуулахаар АТГ-т хүргүүлсэн. <p>4.1.1.1.3.ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • ХАСУМ-д хавсаргаж ирүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, томилогдохоор нэр дэвшсэн ажлын байрны тодорхойлолт, Төрийн албан хаагчийн А-1 дүгээр маягыг тус тус хавсарган 	

		<p>Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.</p> <p>4.1.1.1.5.Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод нээлттэй болгох зорилгоор Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системд 2018 оны I улирлаас эхлэн шинээр дахин бүртгэлжүүлж ажилласан. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхөж байна. Нөхөх боломжгүй тохиолдолд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулах, нөхөх боломжгүй тохиолдолд уг ажлын байранд ажиллах албан тушаалтныг сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх бодлого барьж ажилласан. Байгууллагын сул орон тоог зарлах холбоосыг http://mcud.gov.mn цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал→ хүний нөөц→сул орон тооны зар хэсэгт байршуулсан. Мөн ажлын байрны сул орон тоо гарах бүрд захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж www.csc.gov.mn цахим хуудсанд зарлуулдаг. Тайлант хугацаанд Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/116 дугаар “Ажлын байрыг нийтэд зарлуулах тухай” албан бичгээр Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Инженер, геологийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтний ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолт болон бусад материалын хамт хүргүүлсэн. Сонгон шалгаруулалт 2018 оны 6 дугаар сар 12-ны өдөр бүртгэж 22 бүртгүүлснээс 2 хүн тэнцсэн. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/111 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2018 оны А/160 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журамд оруулах нэмэлт оруулах тухай” болон Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/02 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн хорооны ажиллах журам”, ажлын байрыг нийт албан
--	--	--

		<p>хаагчдад болон яаманд шинээр томилогдсон албан хаагчдад танилцуулан байгууллагын дотоод удирдлагын систем болох ABLE систем болон Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудсанд http://mcud.gov.mn-д байршуулан үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийг хуралдуулж Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Батдэлгэрийн Нямдоржийг сонгон шалгаруулалтын журмаар, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Билэгжаргал, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Алтайбаатар, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Тилеухан нарыг жинхлүүлэх, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн, Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын норм, нормативын бодлого, суурь судалгаа, статистик мэдээлэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Г.Эрхэмбаяр, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Геодези, зураг зүй, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхсайхан, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Усны барилга байгууламжийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Д.Мөнгөнсүвд, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн П.Ганбаатар, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Г.Гантөр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Тилеухан, мөн газрын мэргэжилтэн Б.Даваасүрэн, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Нямдаш нарын албан хаагчдын Төрийн захиргааны албан хаагчийн тангарагыг өргүүлэх асуудлыг шийдвэрлэв. Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Б/59 дугаар тушаалаар Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, ажил, албан тушаалын жагсаалт, чиг үүргийг шинэчлэн нийт 78 орон тоо баталснаас одоогоор 73 албан хаагч ажиллаж байгаа. Үүнээс ТЗУГ-3, ББМУБХЗГ-1, ХШҮДАГ-2, нийт 6 сул орон тоог нөхөх чиглэлээр ажилласан байна. Ингэхдээ харьяа байгууллагаас албан хаагчийг шилжүүлэн авах зэрэг хүний нөөцийн нөөцийн дотоод боломжийг ашиглах бодлого, чиглэлийг баримталж ажилласан. Ажлын байрны хэрэгцээ, тухайн ажлын байранд тавигдах шаардлага, албан хаагчийн мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага зэргийг харгалзан 10 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан. Сонгон шалгаруулалтгүй түр томилогдсон 5 албан хаагчдын</p>
--	--	--

албан хаагчийн сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 03/4036 тоот албан бичгээр хүргүүлж, сонгон шалгаруулалтыг зарлуулж, ТАЗ-ийн дүгнэлт, АТГ-ын саналыг үндэслэн томилсон. Төрийн албаны зөвлөлийн БХБЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 3 дугаар сарын 18-нд Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар баталж, хэрэгжүүлэн ажилласан. Салбар зөвлөлийн жилийн төлөвлөгөөг батлах, албан хаагчдад зэрэг дэв олгох, цалингийн шатлалыг ахиулах, төрийн жинхэнэ албаны тангараг өргүүлэх, томилох, өргөдөл гомдлыг барагдуулах зэрэг асуудлаар 2018 онд 3 хурлаар 9 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн. Салбар зөвлөлөөс гаргасан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдамжаар ханган ажиллаж сул орон тоо, нөөцөд бүртгэгдсэн, сул ажлын байрыг нөхөж байх зэрэг асуудлыг байнга танилцуулах үүргийг өгсөн. БХБЯ-ны Салбар зөвлөлийн төрийн албан хаагчийн нөөцийн санд 16 хүн бүртгэлтэй байна.

4.1.1.2.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, зөвлөмжийг удирдлага болгон ажиллаж байна.
- Дээрх баримт бичгийн хүрээд яамны "Хөдөлмөрийн дотоод журам" /журмын 3, 4-р зүйлд тусгасан/-д албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг ерөнхийлөн зааж, ажлын байрны тодорхойлолтод тусган, хэрэгжилтийн тайланг улирал бүр авч, хяналт тавьж ажиллав.

4.1.1.7.1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 3-р бүлэг заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэдэг. Яамны зүгээс өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах үйл ажиллагааг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар ABLE soft ХХК-иар ABLE системд

		<p>бүртгэх, хэрхэн шийдвэрлэсэн, ямар хариу өгсөн эсэх, тухайн жилд хэдэн өргөдөл, гомдол, мэдээлэл ирсэн зэрэг цогц шийдлийг бий болгосон. Энэ нь яамны бүх албан хаагчдад нээлттэй төдийгүй “олон нийтийн хэлэлцүүлэг” гэсэн цахим буланд асуудлыг хэлэлцүүлж хэвшүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Авлигатай тэмцэх газраас хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотойгоор яамны 1 албан хаагчид хариуцлага тооцуулахаар албан бичиг ирүүлсний дагуу Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар цалингийн 3 сарын 30 хувь хасах сахилгын арга хэмжээ авсан. Үүнийг яамны нийт албан хаагчдад сонсож танилцуулсан болно. <p>4.1.1.9.1.Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яамны албан хэрэг хөтлөлтийн ABLE программ хангамжийг ABLE soft ХХК-иас 2015 оноос эхлэн ашиглаж байна. Тус программ хангамжийн ашиглалтын талаар яамны албан хаагчид бүрэн мэдээ, мэдээлэлтэй байдаг тул нийтийн түлхүүрийн дэд бүтцийг энэхүү програмд уялдуулан ашиглах талаар судалгаа хийж байна. • Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллага болох "Мон Пасс" ХХК болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран тоон гарын үсэг, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн чиглэлээр яамны газар, хэлтсийн дарга нарт 2017 оны 04 сард сургалт зохион байгуулсан. 2018 оны I улиралд багтааж нийт удирдах албан тушаалтнуудыг тоон гарын үсгийн эрхийг авч яамны удирдлагууд болон ТЗУГ-ын албан хаагч нийт 40 хүнд тоон гарын үсэг ашиглах төхөөрөмжийг авсан бөгөөд 2019 оноос хэрэгжүүлж, ашиглахад бэлэн болоод байна. <p>4.1.1.10.1.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах арга хэмжээний хүрээнд:</p> <p><i>Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын албан хаагчдыг сургах хүрээнд дараах сургалт, түүнтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэв:</i></p> <ul style="list-style-type: none"> • Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтаас 2018 оны 01 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн байгууллагын стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ” сэдэвт богино хугацааны сургалтад Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Ж.Түвшрэхийг оролцуулав. Барилга, хот байгуулалтын салбарын чиглэлээр аймаг, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн ажилтнуудыг оролцуулан 2018 онд зохион байгуулах сургалт, семинарын төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2018.01.04-ний өдөр 03/43 дугаартай
--	--	---

		<p>албан бичгээр хүргүүлэв. Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтээс 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд зохион байгуулах “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Албан хэрэг хөтлөлт” сэдэвт зайн сургалтуудад тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн мэргэжилтэн Э.Эрдэнэбат, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Мөнгөнсүвд, Төрийн захиргааны удирдлагын газрын Архивч Б.Мөнхтуул, Бичээч, операторч Ю.Нямсүрэн нарыг оролцуулав. Төрийн захиргааны менежментийн магистрын 2018 оны “Гарагийн сургалт”-д Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Агвааны Энхтүвшин суралцаж байна. Батлан хамгаалах яамнаас 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал-Орон нутгийн хамгаалалт” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Амартүвшин, Э.Эрдэнэбат нарыг оролцуулав. Төрийн албаны зөвлөлөөс Япон Улсын Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам, Мэйжигийн Их сургуультай хамтран 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдөр бүтээн байгуулалт, барилгын салбарын менежмент болон удирдах албан тушаалтны үүрэг хариуцлагын чиглэлээр зохион байгуулсан сургалтад салбарын 45 албан хаагчдыг оролцуулав. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-аас 2018 оны 8 дугаар сарын 09-ний өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Urban Development Policy” сэдэвт урт хугацааны магистрын шалгалтад тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Г.Эрхэмбаяр тэнцэн “Чунг-Анг”- их сургуульд, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн С.Золжаргал Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын “Вестминстерийн Их сургууль”-д хот төлөвлөлт ба тогтвортой хөгжлийн чиглэлээр магистрантурт тус тус элсэн суралцаж байна. 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс 7 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Capacity Building for National Surveying & Mapping Organization” сэдэвт сургалтад тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарантуяа, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Э.Усанболор, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Г.Болормаа, мэргэжилтэн Б.Мөнхсайхан нар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /JICA/-аас 2018 оны 10 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд Япон Улсад зохион байгуулагдсан “Бодлого, төлөвлөлт, хэрэгжилт” сэдэвт богино хугацааны сургалтад Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Монголжингоо тус тус оролцов.</p>
--	--	---

		<p>Мэдээлэл, технологийн үндэсний паркаас 2018 оны IV улиралд зохион байгуулах “Сүлжээ”, “Хакер 1.0” сэдэвт сургалтуудад тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Д.Баярмаа оролцов. Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтаас 2019 онд зохион байгуулах богино хугацааны 21 чиглэлийн сургалтад 54 ажилтанг оролцуулах саналыг 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 03/3782 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p> <ul style="list-style-type: none"> • Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газраас ТА-ны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар 3 удаагийн мэдээллийг хийж, яамны болон харьяа байгууллагын албан хаагчдыг оролцуулсан. Уг арга хэмжээнд нийт 78 албан хаагчид оролцсоны 15 удирдах албан тушаалтан, 63 албан хаагчид байв. <p>4.1.1.10.2.Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах арга хэмжээний хүрээнд:</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлд төрийн байгууллага нь “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны А/134 дүгээр тушаалын хавсралтаар “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2018 онд батлан хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгасны дагуу “Төрийн байгууллагын стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Албан хэрэг хөтлөлт”, “Бүтээн байгуулалт барилгын салбарын менежемент болон удирдах албан тушаалтны үүрэг хариуцлага”, “Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт”, “Нягтлан бодогчийн сургалт”, “Сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, техник болон програм хангамжийн хэвийн ажиллагаа, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлын хангалт”, “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторуудад зориулсан чадавхийн сургалт”, “Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн сургалт”, “Полимер мембран Logicroof-ыг ашиглах, суурилуулах аргачлал”, “Цэг тэмдэгт, байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг хөтлөх сургалт”, “Геологи, орчны мэдээллийн сан, газар хөдлөлийн бичил мужлалын мэдээллийн сангийн хэрэглээ”, “Инженер хайгуул, мониторингийн мэдлэг, мэдээлэл солилцох сургалт”, сумын даамлуудад зориулсан “Цэг тэмдэгтийн мэдээллийн сан хөтлөх, том, дунд маштабын байр зүйн зургийн жижүүрлэлт хөтлөх, тодруулалт, шинэчлэлт хийх аргачлал”, “Бохир усны шугам сүлжээ ба цэвэрлэх технологи /ахисан түвшний/”, “Эрчим хүчний хэмнэлттэй барилга”, “Төрийн захиргааны</p>
--	--	--

		<p>менежерийн магистрын сургалт”, “Хот төлөвлөлт ба тогтвортой хөгжил /магистрын/”, “Монгол Улсад эрчим хүчийг хэрхэн хэмнэх ба байгаль орчныг хамгаалах”, “Авлигын эсрэг”, “Бодлого, төлөвлөлт, хэрэгжилт” сэдвүүдээр дотоод гадаадад зохион байгуулагдсан урт богино, дунд хугацааны сургалтуудад мэргэжилтнүүдийг давтан сургалаа.</p> <p>4.1.1.10.3.Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг яам болон түүний харъяа төрийн байгууллагууд нийт ажилтнууддаа жилд тогтмол хийж байгаа бөгөөд төрийн албанд анхлан орж буй ажилтнуудад тусгайлан зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. Мөн уг асуудлыг хариуцсан мэргэжилтэн АТГ-аас зохион байгуулагдсан сургалт, семинарт тогтмол оролцож, яамны нийт албан хаагчдад танилцуулга хийн мэдээллээр ханган ажиллав. Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвийн авлигын эсрэг сургалтын хөтөлбөрийн хүрээнд тус яамнаас нийт 57 албан хаагчийг оролцуулсан. • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийг биелүүлж ажиллах, эс биелүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар мэдээлэл хийж, шилэн дансны мэдээлэлд оруулах мэдэгдлийг тендер нээсэн тухай бүр гаргаж байх үүрэг даалгаврыг тендер шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар болон Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, мэргэжилтэнд өгсөн. Өмнөх саруудад өгөөгүй байсан мэдэгдэх хуудсыг нөхөн гаргуулж шилэн дансны мэдээллийн санд нөхөж оруулсан. <p>Яамны шинэчлэгдсэн цахим хуудсанд “Авлигыг мэдээлэх утас” баннерыг байршуулсан.</p>
2-р зорилтын хүрээнд:		<p>4.1.2.1.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим засгийг боловсронгуй болгоход чиглэсэн "Цахим засаглал үндэсний хөтөлбөр" боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт тус яамыг төлөөлж ажилласан. Энэхүү ажлын хэсэгт Барилга, хот байгуулалтын салбарын цахим засгийн чиглэлээр хэрэгжүүлж болох цахим үйлчилгээг судлах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ, анализ хийх зэргээр салбарын оролцоог ханган ажиллав. • Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудсыг шинэчлэх ажил хийгдэж дууссан. Энэ ажлын хүрээнд цахимаар өргөдөл гомдол хүлээн авах модуль,

		<p>цахим хэлэлцүүлэг, санал асуулгын модуль, салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм журам, норм нормативийн бичиг баримтын нэгдсэн сангийн модуль зэрэг шинэ боломжуудыг цахим хуудасны програм хангамжид хөгжүүлж ажилласан. Мөн Барилгын салбарын тусгай зөвшөөрлийг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, www.tz.mncud.gov.mn цахим системийг туршилтын байдлаар ашиглалтад оруулсан. Энэ цахим систем нь Төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холбогдож байгаа ба бусад төрийн байгууллагын мэдээллийн сан руу ХУР системээр дамжин холбогдох боломжтой юм. Ингэснээр аж ахуйн нэгж, иргэдээс шаарддаг зарим төрлийн лавлагаа, тодорхойлолт зэргийг ХУР системээс татаж авах боломжтой. Энэхүү нэгдсэн сүлжээг бий болгосноор мэдээлэл солилцооны хурд өсөж, төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай хүргэх боломжтой болж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн нэгдсэн судалгааг гаргаж, яамны веб сайт, able системд байршуулсан. Сайдын хэм хэмжээ тогтоосон 124 шийдвэрийг яамны цахим хуудаст байршуулсан. • Шилэн дансны хуулийн дагуу яамны урсгал зардал болон барьцаа хөрөнгөтэй холбоотой 5 сая төгрөгөөс дээш 5,594.5 сая төгрөгийн 127 ширхэг гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд тухай бүр нь байршуулсан. Мөн тухай бүр, сар бүр, улирал бүр, жилээр оруулах мэдээ мэдээллийг шилэн дансанд байршуулсан. • Сайдын тушаал 10 боть, ТНБД-ын А,Б тушаал 5 боть, Барилгын салбарын хэмжээнд ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээ 13 боть, 2013 оны гэрээ 14 боть хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт оруулж бүртгэсэн. • Байгууллагын сул орон тоог зарлах холбоосыг http://mncud.gov.mn цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал→ хүний нөөц→сул орон тооны зар хэсэгт байршуулсан. Мөн ажлын байрны сул орон тоо гарах бүрд захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж www.csc.gov.mn цахим хуудсанд зарлуулдаг. • Сүлжээний аюулгүй ажиллагааг хангах зорилгоор Palo alto 220 төхөөрөмжийг шинээр худалдан авч, суурилуулан ажилласан. <p>4.1.2.1.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Салбарын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах” хөтөлбөрийг боловсруулан харъяа агентлагуудаас санал авахаар хүргүүлсэн. • Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нийслэл, 9 дүүргийн Газрын албаны кадастрын мэдээллийн санд
--	--	---

		<p>нэвтрүүлэх, нэгдсэн сүлжээнд холбох ажлыг хийж байна. Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах ажлын үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/10 тушаалаар байгуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Газар дэлхий” ХХК-тай 2018 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 03 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Тус гэрээнд заасан үүргээ биелүүлж “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим систем байгуулах” гэрээт ажлын эхлэлийн (80 хуудас бүхий) тайланг ирүүлж энэхүү гэрээнд заасан хугацаанд захиалагчид хүлээлгэн өгсөн. Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах ажлын эхлэлийн тайланг 2018.10.01-ны өдөр ирүүлж, эхлэлийн тайланг хүлээн авч дүгнэлт, акт үйлдэн Сангийн яаманд хүргүүлээд байна.</p> <ul style="list-style-type: none"> • Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн ажлын хүрээнд байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчдэд түргэн шуурхай түгээх зорилгоор https://geoportal.nsd.gov.mn хаягийг ажиллуулж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлал - Улаанбаатар хот, Төв аймаг - Зуунмод хот орчмын төлөвлөлтүүд - Бэлчээрийн фото мониторинг - Хөдөө аж ахуйн мэдээ, мэдээлэл - Газрын дуудлага худалдааны байршил - Геологи орчны мэдээллийн сан (туршилт) - Нийгэм эдийн засгийн мэдээллийн сан - Авто болон төмөр замын төлөвлөлт • Газрын биржийн цахим систем: Газар зохион байгуулалтын бүх төрлийн төлөвлөгөө, Газрын кадастрын мэдээллийн сан болон Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн экологи, геологи орчны мэдээллийн сантай давхцуулан байршилд суурилсан дээрх мэдээ, мэдээллийг www.mle.mn хаягаар авах боломжтой. Үүнд: • Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа • Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт • Газар өмчлөх болон эзэмших эрхээ бусдад шилжүүлэхтэй холбогдсон арилжаа • Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ болон газартай холбоотой бусад мэдээлэл • Интернет орчинд гар утас ашиглан Газартай холбоотой бүхий мэдээллийг www.gazar.gov.mn хаягаар олон нийт авах боломжийг бүрдүүлсэн. <p>Өргөдлийн дугаар, Регистрийн дугаараар хайх</p>
--	--	---

		<ul style="list-style-type: none"> • Өргөдлийн төрөл • Өргөдөл өгсөн огноо • Өргөдлийн явц • Хариуцсан мэргэжилтэн • Шилжүүлсэн мэргэжилтэн • Мэргэжилтний утасны дугаар • Нэгж талбарын дугаар, гэрээний дугаар хамт хайх • Газар ашиглалтын төрөл • Гэрчилгээний дугаар • Гэрээ байгуулсан огноо. • Гэрээний дуусах хугацаа • Газрын төлбөрийн мэдээлэл • Газрын төлбөр төлсөн байдал • Талбайн хэмжээ • Аймаг, сум, хаягаар хайх • Нэгж талбарын дугаар • Талбайн хэмжээ • Баг/хороо • Хаягийн мэдээлэл • Хэрэглэгчийн нэр, нууц үг ашиглан хайх • Нэг удаа газар өмчилсөн эсэх • Газар ашиглалтын төрөл • Захирамжийн огноо • Нэгж талбарын дугаар • Талбайн хэмжээ • Хаягийн мэдээлэл • Захирамжийн дугаар • Захирамжийн огноо • Өргөдлийн дугаар • Объектын мэдээлэл харах • Нэгж талбарын дугаар • Хаягийн мэдээлэл • Талбайн хэмжээ • Зориулалт <p>• Монгол Улсын их хурлын 2016 оны 71 дүгээр тогтоол /Эдийн засгийг сэргээх хөтөлбөр/, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх үндсэний хөтөлбөрт тусгасан ажлын хүрээнд Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимаар хүлээн авах ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нээлтийн ёслолын ажиллагааг зохион байгууллаа. Аж ахуйн нэгж байгууллагууд tz.mcud.gov.mn хаягаар хандаж хүсэлтээ илгээнэ. Энэ өдрөөс эхлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг цаасан хэлбэрээр бүрдүүлдэг байсан бол өнөөдрөөс эхлэн цахим хэлбэрээр хүсэлтээ илэрхийлж, олон шат дамжлаг дамжиж хүний гараар шалгадаг байсан ажлын ачааллыг багасгаж,</p>
--	--	---

		<p>инженер техникийн ажилчдын давхцалыг арилгаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг чанаржуулах томоохон алхам нээгдэж байгаа билээ. Энэхүү программ нь төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны хур системд холбогдож, Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг байгууллагуудын мэдээлэлтэй тулгалт хийж шалгах боломжтой болсон.</p> <p>Цахим системд шилжсэнээр тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн баримт бичгийг автоматаар шалгаж, иргэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн сан бүрдэх, системийн тусламжтай төлбөр төлөх, Тусгай зөвшөөрөл хүсэхээс эхлээд бүх шат дамжлагыг автоматжуулсан, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны идэвхитэй үед тавих хяналт сайжрах юм. Мөн төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх, Барилгын салбарын инженер техникийн ажилчдын нэгдсэн мэдээллийн сан бүрдэх, Салбарын бодлого боловсруулахад шаардлагатай суурь мэдээлэл, тайлан, мэдээ гаргахад нөхцөл бүрдэх, Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд, холбогдох журамд заасан шалгуурыг ханган ажиллаж байгаа эсэхэд тавих хяналт, Төр, иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын харилцан итгэлцлийг бэхжүүлж, нээлттэй ил тод байдал сайжирна.</p> <p>4.1.2.2.2.Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 215 дугаар тушаалаар барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсний дагуу Барилга, хот байгуулалтын яам, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагатай 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 2018/19 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. • Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан чиг үүргийг мөн хуулийн 18.4-т заасны дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” гэрээг Монголын барилгачдын үндэсний ассоциаци ТББ-тай 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. • Барилгын хөгжлийн төвд шилжүүлсэн чиг үүрэг: “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай 2018 оны 2-р сарын 14-ний 51 дүгээр тогтоолоор Барилгын тухай хуулийн 34.1.2 /34.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах;/, 34.1.4 /34.1.4.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;/, 34.1.6 /34.1.6.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг
--	--	---

сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;/, 34.1.7 /34.1.7.барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;/, 34.1.8 /34.1.8.барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах/, 34.1.9 /34.1.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох; /, 34.1.10 /34.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;/ 34.1.11 /34.1.11.зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;/, 34.1.13 /34.1.13.архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;/, 34.1.15 /34.1.15.барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;/-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг “Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр болсон.

4.1.2.2.3.Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга хэмжээний хүрээнд:

- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу **Барилга, хот байгуулалтын яам болон “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-тай** байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх, тусгай зөвшөөрлийн урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээ, үйлчилгээний хураамж норм нормативын сангийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалтыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 14-ны хооронд хийсэн.
- “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т төвлөрсөн норм, норматив боловсруулах сангийн орлогыг 2018 оны 01 сарын 25-наас 2018 оны 06 сарын 01-ны өдөр хүртэлх хугацааг хамруулан шалгасан болно. Үүнд:
 - 2018 оны 01 дүгээр сарын 25-ний өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ийн норм, норматив боловсруулах сангийн шимтгэл:
 - Барилгын хөгжлийн төвийн төвлөрүүлсэн – 514,031.5 мянган төгрөг
 - МБҮАссиосацийн төвлөрүүлсэн - 450,976.6 мянган төгрөг,
 - ГЗБГЗЗГазраас өмнөх оны төвлөрүүлэлт 361,197.9 мянган төгрөг нийт **1,326,206.0** мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

4.1.2.4.3.Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үр дүнгийн гэрээнд “Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, түүний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах тайлагнах” гэсэн байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангах хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 483 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны “Барилга, хот байгуулалтын яам, салбарын агентлаг, төв, институтын үйл ажиллагааны явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам батлах тухай” 29 дүгээр тушаал, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт ба хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх журам батлах тухай” 26 дугаар тушаал, Дотоод аудитын дүрэм болон Олон Улсын Мэргэжлийн Практикийн Хүрээ, Дэлхийн Банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслөөс эрхлэн хэвлүүлсэн Улсын салбарын дотоод аудитын гарын авлага болон холбогдох хууль тогтоомж, шийдвэр зэргийг мөрдлөг болгон ажилласан. 2017 оны жилийн эцсийн байдлаар тус газрын төлөвлөгөөнд туссан ажлын гүйцэтгэл 98,5 хувьтай хэрэгжсэн байна. Барилга, хот байгуулалтын сайдын баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу ТОСК ТӨҮГ, БХТөв ТӨҮГазрын Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа, Норм, нормативын сангийн үйл ажиллагаа, Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт болон хилийн ойролцоох суурин газруудын хөгжлийн төсөл /G0204-MON/-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн дүгнэлт зөвлөмж боловсруулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

4.1.2.7.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд яам, салбарын бодлого үйл ажиллагаа нь иргэн аж ахуйн нэгж байгууллагад хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх, барилга, хот байгуулалтын салбарын 2017 оны бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг “Хөгжлийн зөв зам” ТББ гүйцэтгэн, дүнг яамны удирдлагуудад танилцуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

		<ul style="list-style-type: none"> Барилга, хот байгуулалтын салбар дахь төрийн зохицуулалт, бүртгэл, зөвшөөрөл, хяналтын механизмыг хараат бусаар, хөндлөнгийн байр суурьнаас нарийвчлан судлаж авлигын эрсдэлийг тодорхойлж байгаагүй боловч “Монголын маркетингийн судалгааны ассоциаци” ТББ-аас анх удаа энэхүү үнэлгээг хийж, тайланг 2018 оны 12-р сарын 23-ны өдөр тус яаманд хүлээлгэж өглөө. Энэхүү хөндлөнгий үнэлгээний зөвлөмжид туссан асуудлыг 2019 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.
3-р зорилтын хүрээнд:		<p>4.1.3.2.2.Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> Барилга, хот байгуулалтын яамны 2017 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар 3 зөвлөмж, 1 албан шаардлага бүхий "зөрчилгүй санал дүгнэлт"-тэй дүгнэгдсэн. Мөн БХТөв ТӨҮГазрын Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа, Норм, нормативын сангийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж 6 зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. <p>4.1.3.4.2.Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> Шилэн дансны тухай хуулийг мөрдөн, холбогдох журмын дагуу байгууллагын үйл ажиллагаа болон төсөв санхүүтэй холбоотой тайланг хуулийн хугацаанд нь тайлагнаж, мэдээллийн самбарт байршуулж мэдээлж байна. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам болон Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна. <p>4.1.3.7.2.Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Төрийн албаны тухай <i>Ишинэчилсэн найруулга</i> хуулийн 50 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ. Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах шинэ

		<p>зохицуулалтыг тусгасан байна. Дээрх шинээр баталсан хуулийн дагуу төрийн албан хаагчийг хууль бусаар халсан тухай шүүхийн шийдвэртэй нэг албан хаагчийг эрхэлж байсан албан тушаалд нь эгүлэн томилсон.</p>
	<p>7-р зорилтын хүрээнд:</p>	<p>4.1.7.1.1.Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тус яамны зүгээс боловсруулж буй хууль тогтоомжууд, бодлогын баримт бичиг, норм дүрэм, журам зааврын төслүүдийг байгууллагын https://mcsud.gov.mn/ld?typeId=7 цахим хаягт тухай бүр бүр байршуулан санал авч байна. <p>4.1.7.3.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 хэсэгт захиргааны байгууллагаас аливаа хэлбэрээр шийдвэр гаргах нөхцөлд сонсох ажиллагаа явуулах арга хэлбэрийг тусгасан байдаг. Энэ дагуу тус яамнаас www.mcsud.gov.mn цахим хуудаснаа одоогоор олон нийтийн хэлэлцүүлгийн талбарыг боловсруулж байршуулсан. • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт заасны дагуу яамнаас худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгчийн заавал оролцуулж хэвшсэн. <p>4.1.7.3.2.Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тус яамнаас ТББ, мэргэжлийн холбоонд төрийн зарим чиг үүргийг шилжүүлсэнээр улсын төсвөөс хөрөнгө гарахгүй. • Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 169 дүгээр тушаалаар “Архитектор, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл” /цаашид “зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг Монголын архитекторуудын эвлэлээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 102 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. • Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 170 дугаар тушаалаар “Барилгын салбарын архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүрэг”-ийг Монголын архитекторуудын эвлэлээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2016 оны 12

		<p>дугаар сарын 07-ны өдөр 103 тоот гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 186 дугаар тушаалаар байгуулсан, Барилгын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн зарим чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. • Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 215 дугаар тушаалаар барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг барилгын салбарын төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсний дагуу Барилга, хот байгуулалтын яам, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагатай 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 2018/19 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. • Барилгын хөгжлийн төвд шилжүүлсэн чиг үүрэг: “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай 2018 оны 2-р сарын 14-ний 51 дүгээр тогтоолоор Барилгын тухай хуулийн 34.1.2 /34.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах;/, 34.1.4 /34.1.4.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;/, 34.1.6 /34.1.6.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;/, 34.1.7 /34.1.7.барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;/, 34.1.8 /34.1.8.барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах/, 34.1.9 /34.1.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох;/, 34.1.10 /34.1.10.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;/ 34.1.11 /34.1.11.зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;/, 34.1.13 /34.1.13.архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;/, 34.1.15 /34.1.15.барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;/-д заасан барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг “Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр болсон. • Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн жагсаалтыг байгууллагын https://mcud.gov.mn/as/tz цахим хаягт байршуулан тухай бүр шинэчилж байна.
--	--	--

		<ul style="list-style-type: none"> • Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимаар хүлээн авах ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нээлтийн ёслолын ажиллагааг зохион байгуулсан. Аж ахуйн нэгж байгууллагууд tz.mcud.gov.mn хаягаар хандаж хүсэлтээ илгээх бөгөөд тус өдрөөс эхлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг цаасан хэлбэрээр бүрдүүлдэг байсан бол өнөөдрөөс эхлэн цахим хэлбэрээр хүсэлтээ илэрхийлж, олон шат дамжлаг дамжиж хүний гараар шалгадаг байсан ажлын ачааллыг багасгаж, инженер техникийн ажилчдын давхцалыг арилгаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг чанаржуулах томоохон алхам нээгдсэн билээ. Энэхүү программ нь төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны хур системд холбогдож, Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг байгууллагуудын мэдээлэлтэй тулгалт хийж шалгах боломжтой болсон. • Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг яамны https://mcud.gov.mn/as/projectnews цахим хаягт байршуулан мэдээллийг тухай бүр шинэчилж байна. <p>4.1.7.4.1.Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яаманд ажиллах дэд зөвлөлийн гишүүдтэй 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хамтран ажиллах гурвалсан гэрээ байгууллаа. Тус зөвлөл нь С.Энхбадрал, С.Төмөрбаатар, Гэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажиллах бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, хөхиүлэн дэмжих, төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүйд хяналт тавих чиглэлээр тус яам болон АТГ-тай хамтран ажиллана.
	10-р зорилтын хүрээнд:	<p>4.1.10.1.1.Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сар бүр шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээллийг оруулан ажиллаж байна. • Яамны шинэчлэгдсэн цахим хуудсанд “Авлигыг мэдээлэх утас” баннерыг байршуулсан. <p>4.1.10.1.4.Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл</p>

		<p>ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> Сүүлийн хоёр жилийн хугацаанд Барилга, хот байгуулалтын яамны хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тус төлөвлөгөөг боловсруулснаар яамны нийт албан хаагчдын авлигаас урьдчилан сэргийлэх ойлголтыг бий болгож, үйл ажиллагаанд ЭБАТ болон удирдах албан тушаалтнууд хяналт тавьдаг. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланд мониторинг хийсэн.
9.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ul style="list-style-type: none"> Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд авлигын эсрэг арга хэмжээ нэг мөр болж хэвшсэн бөгөөд цаашид боловсронгуй болох асуудлууд байна. Тухайлбал: <ol style="list-style-type: none"> Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр АТГ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх, санаачилга гаргах; Үйл ажиллагааны ил тод байдалд үнэлгээ хийхэд Иргэний хяналтын зөвлөл, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх; Тайлант хугацаанд Төрийн албаны шинэ хууль батлагдаж хэрэгжээд удаагүй байгаатай холбоотойгоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ тухайлбал: Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байсан.
10.	Санал	<ul style="list-style-type: none"> Яамны албан хаагчийн үр дүнгийн гэрээг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй уялдуулах талаар зөвлөмж ирүүлэх; ЭБАТ-уудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Ажлын албаны зүгээс уулзалт, арга хэмжээ зохион байгуулах саналтай байна;
11.	Шаардагдах төсөв	---
12.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Авлигатай тэмцэх газрын зүгээс өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамтай ЭБАТ-аар дамжуулан байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна. Олон нийтийн хяналтын гишүүдтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг шинэчлэн байгуулсан.
13.	Сургалтад	Тайлант хугацаанд АТГ-аас зохион байгуулсан төлөвлөгөөт

	хамруулах албан хаагчийн тоо	сургалтад тус яамнаас давхардсан тоогоор 57 албан хаагч хамрагдсан бөгөөд цаашид яамны нийт албан хаагчдыг давтан сургалтад хамруулах саналтай байна.				
14.	Бүх шатны төрийн байгууллагад хамаарах					
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		96,6%	3	100%	100%	90%
15.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 7	Зорилт 10	-
		70%	2	70%	70%	-
18.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (АТГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ